



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 280

Улаанбаатар хот

Гэрээний үндсэн дээр ашиглуулж, дэмжлэг үзүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гадаад харилцааны сайдын 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 08/2906 дугаар албан бичгээр ирүүлсэн санал, “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын хүсэлтийг харгалзан, тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Сүхбаатар дүүргийн 7 дугаар хороо, Эрхүүгийн гудамжинд байрлах 800 м.кв талбай бүхий 11 дүгээр байрыг “Монгол Цэргийн Нэгдсэн Холбоо” төрийн бус байгууллагад гэрээний үндсэн дээр ашиглуулахыг зөвшөөрсүгэй.

2. “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ё.Нямжавт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1.Зохих журмын дагуу холбогдох гэрээ байгуулж ажиллах;


2.2.Байр талбайн ашиглалтын зардлыг түрээслэгч хуулийн этгээдэд хариуцуулах;

2.3.Ашиглалтын гэрээний үүргийн биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг тухай бүр ирүүлж байх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ГАНБАТ

А.АРИУНБОЛД